

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ТОГТООЛУУДЫН ХЭРЭГЖИЛТ
(2026.02.05)

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Засгийн газрын тогтоолын огноо, дугаар	Арга хэмжээ	Биелэлт	Хариуцах газар	Хариуцах нэгж
2	2025.04.14-ний өдрийн 185	1.Хангайн бүсийн нутаг дэвсгэрт үүлний шилжилт, хувьслыг өндөр нарийвчлалтай тодорхойлох, цаг агаарын гамшигтүзэгдлийг урьдчилан илрүүлж мэдээлэх, эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бэхжүүлэх хүрээнд иж бүрэн тоног төхөөрөмж бүхий цаг уурын радарын станцыг Өвөрхангай аймгийн Хархорум хотод байгуулж, найдвартай, тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяад үүрэг болгосугай.	Монгол улсын Засгийн газрын 2025.04.14-ний өдрийн 185 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол улсын 2026 оны төсөвт Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Допплерын радын станцыг Өвөрхангай аймгийн Хархорин сумд, байгуулахад шаардлагатай 9.9 тэрбум төгрөг батлуулсан. Өвөрхангай аймгийн Хархорин сумд байгуулах радарын станцыг худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулан Агентлагийн даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 01/943 тоот албан бичгээр БОУӨЯ, 2026 оны 02 дугаар сарын 02-ний өдрийн 01/75 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлж бэлтгэл ажлыг хангасан.	ЦУОШГ, БТГ	Улсын сүлжээний газр
6	2025.05.12-ны өдрийн 233	1.2.4.Бүсийн агаар, ус, хөрсөн дэх олон төрлийн хорт органик нэгдэл, хүнд металлыг тодорхойлох, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах,	Байгаль орчны шинжилгээний лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлж, чадавхыг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай сайдын тушаалын төслийг боловсруулан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн	ЦУОШГ, БТГ	

		хамгаалах тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийг Говийн бүсийн байгаль орчны шинжилгээний төв лаборатори болгон өргөжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяд.	сайдын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/342 дугаар тушаалаар батлуулсан. Уг тушаалд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан одоогийн бүрдсэн нөөцөд тулгуурлан Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийг Говийн бүсийн төв лаборатори болгон өргөжүүлэхээр заасан. Тушаалыг үндэслэн Говийн бүсийн лабораторийн бүс нутгийн онцлогт тохирсон байгаль орчны хяналт шинжилгээний нарийн хэмжлийн багаж, тоног төхөөрөмжийн холбогдох санхүүжилтийг 2026 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж хамтран ажиллах тухай 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/683 дугаар бүхий албан тоотыг ЦУОШГ-ын даргаас Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбатад хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Эрх зүй, гэрээ хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Болор-Эрдэнэ

Холбогдох утас: 51-264952

Өрөөний дугаар: 404 тоот

email: bolor-erdene@namem.gov.mn